



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/100

Алтрага

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд харах үйлчилгээний төюд хүүхэд харагчийн бүрдүүлэх баримт бичгийг хянан үзэсний үндсэн дээр Баянзүрх суман дахь нэр бүхий иргэдэд "Хүүхэд харах үйлчилгээг эрхлэх" зөвшөөрлийг олгосугай.

2. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх иргэдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй иргэдэд байнгын хяналтыг тавьж, тайланг улирал тутам Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Г.Пүрэв-Очир)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч (А.Дэлгэрмаа)-д даалгасугай.

ДАРГА



Г.ОДСЭР